

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРӨЛ

Энэхүү зөвшөөрөл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах тухай хуулийн зохицуулалтыг үндэслэсэн болно.

1. Мэдээллийн эзний мэдээлэл:

Эцэг (эх)-ийн нэр	
Өөрийн нэр	
Регистрийн дугаар (иргэний бүртгэлийн дугаар)	
Холбоо барих мэдээлэл	

2. Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл:

Мэдээлэл хариуцагчийн оноосон нэр	"Үндэсний давхар даатгал" ХК
Регистрийн дугаар	5885612
Холбоо барих мэдээлэл	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 106 байр, Бизнес тауэр, 20 давхар Утас: 75770002

3. Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах үндэслэл:

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22.2, Компанийн тухай хуулийн 81.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2-т заасныг тус тус үндэслэн "Үндэсний давхар даатгал" ХК-ийн гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах.

4. Мэдээлэл хариуцагчийн цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт:

- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчлэх баримт бичиг (компанийн засаглалын гэрчилгээний хуулбар болон бусад);
- Иргэний үнэмлэхийн хуулбар (иргэний үнэмлэхийн лавлагааг давхар хавсаргах);
- Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;
- Цээж зураг, 2 хувь (4х3-ийн хэмжээтэй бөгөөд нэг ширхэг нь анкет дээр наагдсан байх);
- Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгүүлж байсан эсэх лавлагаа (иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт);
- Даатгалын компанийн хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох этгээд бус байх лавлагаа (улсын бүртгэлийн байгууллагаас холбогдох лавлагаа, тодорхойлолт авч ирүүлэх);
- Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа (Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Шүүхийн тусгай архивын лавлагаа);
- Холбогдох хууль тогтоомж, энэ зард заасан шаардлагыг хангаж байгаагаа илэрхийлсэн баталгааны хуудас болон тавигдах шаардлагуудыг хангасан талаарх нотлох баримт (Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох байгууллагын лавлагаа, тодорхойлолт гэх мэт).

5. Мэдээлэл хариуцагч мэдээллийг боловсруулж, ашиглах хугацаа:

Цуглуулсан мэдээллийг энэхүү зөвшөөрлийг гаргасан өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар гүйцэтгэх захирлыг томилох хүртэл хугацаагаар боловсруулж, ашиглана.

6. Мэдээлэл хариуцагчийн нийтэд ил болгох, бусдад дамжуулах мэдээллийн жагсаалт:

Д/д	Мэдээллийн жагсаалт	Нийтэд ил болгох (нийтэд ил болгох бол харгалзах хүснэгтэд + тэмдэглэгээ хийнэ)	Бусдад дамжуулах (бусдад дамжуулах бол харгалзах хүснэгтэд + тэмдэглэгээ хийнэ)
1	Төрийн албан хаагчийн анкет (Маягт №1);		+
2	Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом)-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);		+
3	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчлэх баримт бичиг (компанийн засаглалын гэрчилгээний хуулбар болон бусад);		+
4	Иргэний үнэмлэхийн хуулбар (иргэний үнэмлэхийн лавлагааг давхар хавсаргах);		+
5	Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;		+
6	Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ял шийтгүүлж байсан эсэх лавлагаа (иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт, иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт);		+
7	Даатгалын компанийн хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох этгээд бус байх лавлагаа (улсын бүртгэлийн байгууллагаас холбогдох лавлагаа, тодорхойлолт авч ирүүлэх);		+
8	Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа (Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа, шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Шүүхийн тусгай архивын лавлагаа);		+
9	Холбогдох хууль тогтоомж, энэ зард заасан шаардлагыг хангаж байгаагаа илэрхийлсэн баталгааны хуудас (word файлаар татаж авах) болон тавигдах шаардлагуудыг хангасан талаарх нотлох баримт (Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох байгууллагын лавлагаа, тодорхойлолт гэх мэт).		+

Тайлбар: Гүйцэтгэх захирал нь компанийн эрх бүхий албан тушаалтан тул түүнийг томилохдоо Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газраас холбогдох зөвшөөрлийг авсны дараа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлдэг. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх захирлын зарим мэдээллийг цахим хуудсандаа нээлттэй байршуулдаг.

Иймд эдгээр байгууллага, албан тушаалтанд мэдээллийг дамжуулж, зарим мэдээллийг нийтэд ил болгодог.

7. Мэдээллийн эзний зөвшөөрлөө цуцлах хэлбэр:

Мэдээллийг энэхүү зөвшөөрлийг гаргасан өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар гүйцэтгэх захирлыг томилох хүртэл хугацаагаар боловсруулж, ашигласнаар мэдээллийн эзний зөвшөөрөл цуцлагдана.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

Огноо:

Гарын үсэг: